



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-28, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2024. 04. 19 № 419-03/3081
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай" хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН
А.АДЪЯАСҮРЭН
Ш.АДЬШАА
Н.АЛТАНХУЯГ
С.АМАРСАЙХАН
Г.АМАРТҮВШИН
Ц.АНАНДБАЗАР
П.АНУЖИН
Т.АУБАКИР
Ё.БААТАРБИЛЭГ
Х.БАДЕЛХАН
Э.БАТ-АМГАЛАН

000147

Бат

С.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

Ж.БАТСУУРЬ

Б.БАТТӨМӨР

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Д.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРСАЙХАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРЧУЛУУН

Х.БУЛГАНТУЯА

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

Г.ГАНБОЛД

Н.ГАНИБАЛ

Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Б.ЖАРГАЛМАА

Г.ЗАНДАНШАТАР

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

Ц.ИДЭРБАТ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХ-ОРГИЛ

Г.МӨНХЦЭЦЭГ

Ц.МӨНХЦЭЦЭГ

Н.НАРАНБААТАР

Д.ӨНӨРБОЛОР

Х.НЯМБААТАР

С.ОДОНТУЯА

М.ОЮУНЧИМЭГ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПҮРЭВДОРЖ

Ш.РАДНААСЭД

Ц.САНДАГ-ОЧИР

Д.САРАНГЭРЭЛ

Б.САРАНЧИМЭГ

Ж.СҮХБААТАР

Ц.СЭРГЭЛЭН

Д.ТОГТОХСҮРЭН

Ц.ТУВААН

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Ч.ХҮРЭЛБААТАР

Д.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Ж.ЧИНБҮРЭН

С.ЧИНЗОРИГ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Б.ЭНХ-АМГАЛАН


Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Н.ЭНХБОЛД

Т.ЭНХТҮВШИН

Ж.ЭРДЭНЭБАТ





УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭНХБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-28, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2024.04.17 № УИХ-03/2965

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай" хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 40 хуудастай.

Хүдэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

000165



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ТЭМҮҮЛЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.09 № ХЭГ/693
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт *ok* хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



[Signature]
Д.АМАРБАЯСГАЛАН

000245007781

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална” гэж, мөн зүйлийн 4.1.4-т “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх” гэж тус тус заасан.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд Монгол Улсын нийт малчин өрх болон малчдын тоо, тэдгээрийн насны ангилал зэрэг мэдээллийг тусгаж, малчин өрхийн тоо нэмэгдсэн тухай дурдсан боловч эдгээр малчдаас хэдэн хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөг, хэдэн хувь нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг талаарх тооцоо, судалгаа байхгүй байна.

Мөн 2017 оноос 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдсөн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн үйлчлэлд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллийн улмаас зорилтот бүлэг бүрэн хамрагдаж чадаагүй гэж үзсэн боловч хуулийн үйлчлэлд хамрагдсан малчид болон хамрагдаж чадаагүй малчдын тоо, хувь хэмжээ тодорхойгүй, цаашид хэдэн хувьд нь тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн талаарх мэдээллийг тусгаагүйгээс гадна захиргааны зардал, ачаалал үүсэхгүй тул зардлын тооцоо хийх шаардлагагүй гэж үзжээ.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд нийт 34.4 мянган иргэн тэтгэврийн даатгалын шимтгэлд 76.4 тэрбум төгрөг төлсөн бөгөөд эдгээр даатгуулагчид 2023 оны байдлаар 205.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр авсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 5.1.2-т зааснаар нийгмийн даатгал нь “санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх” зарчимтай.

Тэтгэврийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлээр сангийн алдагдлын хэмжээ жил бүр нэмэгдэж, 2024 онд улсын төсвөөс 1.2 их наяд төгрөгийн татаас авахаар байгаа нь тэтгэврийн даатгалын сан улсын төсвөөс хамааралтай болох нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн даатгалын суурь зарчим хөндөгдөх эрсдэл бий болсныг харуулж байна.

Иймд тус хуулийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх шаардлагыг хангаагүйгээс гадна тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байх зарчимд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгэнэ гэж үзэж байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд 2023 онд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 21.23-т “Малчин, туслах малчин энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.” гэж заасныг дурдах нь зүйтэй байна.

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.1-д “Хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэнэ.” гэж заасны дагуу хуулийн төслөөр зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох болон нэр томьёо, ухагдахууны үүсэл зэрэг мэдээллийг агуулсан дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж ирүүлээгүй нь хуулийн төслийн бүрдүүлбэрийн шаардлагыг хангаагүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР